



## УВС АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



# УВС АЙМГИЙН ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН GROSS DOMESTIC PRODUCT OF UVS AIMAG



Сүүлийн 10 жилд, In last 10 year



Улаангом 2017 он

## Агуулга

1. Дотоодын нийт бүтээгдэхүүнийг тооцох нь
2. Увс аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүнийг улс, баруун бүсийн дундаж үзүүлэлттэй харьцуулах нь
3. Аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүний салбарын бүтэц, харьцуулалт
4. Аймгийн нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүнийг улс, бүсийн дундажтай харьцуулах нь
5. Дотоодын нийт бүтээгдэхүүнд хувийн хэвшлийн салбарын эзлэх хувь, харьцуулалт
6. Дүгнэлт, зөвлөмж



Танилцуулгыг хянасан: П.Тунгалаг /Статистикийн хэлтсийн дарга/  
Боловсруулсан: Г.Сувдаа /Статистикийн хэлтсийн мэргэжилтэн/

## 1. Дотоодын нийт бүтээгдэхүүнийг тооцох нь:

Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) нь тухайн засаг захиргааны нэгжийн эдийн засгийн үйл ажиллагааны цар хэмжээг харуулдаг макро эдийн засгийн чухал үзүүлэлт юм.

Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) нь Үндэсний тооцооны систем (ҮТС)- ийн хүрээнд чухал байр эзэлдэг эдийн засгийн үр дүнг илэрхийлэх нэгдмэл үзүүлэлт бөгөөд Хүний аливаа зорилго чиглэлтэйгээр, тодорхой хэмжээний хөдөлмөр, хөрөнгө зарцуулсан үйл ажиллагааны үр дүнг эдийн засгийн ухаанд ДНБ зэрэг үр дүнгийн үзүүлэлтээр хэмждэг байна.

ДНБ-ийг үйлдвэрлэлийн, эцсийн ашиглалтын, орлогын гэсэн 3 аргаар тооцдог. Нийт үйлдвэрлэлтээс завсрын хэрэглээг хасч нэмэгдэл өртгөөр тооцохыг үйлдвэрлэлийн; эцсийн хэрэглээ, хуримтлал, цэвэр экспортын нийлбэрээр тодорхойлохыг эцсийн ашиглалтын; хөдөлмөрийн хөлс, үндсэн хөрөнгийн хэрэглээ буюу үндсэн хөрөнгийн элэгдэл, үйлдвэрлэл болон импортын цэвэр татвар, үйл ажиллагааны цэвэр ашиг, холимог орлого зэрэг орлогын элементийн нийлбэрээр тооцохыг орлогын арга гэж нэрлэнэ.

ДНБ-ий үйлдвэрлэлийн аргын тооцоо нь эдийн засгийн үйл ажиллагааны салбараар хийгддэг ба эдгээр эдийн засгийн салбарын үйл ажиллагаа нь ДНБ-д ямар хувь нэмэр оруулж байгааг харуулдаг.

ДНБ-ий эцсийн ашиглалтыг эцсийн хэрэглээ (өрхийн аж ахуйн, өрхийн аж ахуйд үйлчилдэг арилжааны бус байгууллагын, төрийн байгууллагын хэрэглээ), хөрөнгийн нийт хуримтлал (үндсэн хөрөнгийн, материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт, үнэт зүйлс), экспорт, импортын үйл ажиллагаа гэсэн үндсэн хүрээ, холбогдох дэд хэсгүүдэд хуваагддаг.

ДНБ-ийг үйлдвэрлэлийн аргаар тооцсоноор улс орны эдийн засгийн өсөлт, түүний бүтцийн байдалд дүн шинжилгээ хийхийн хамт ҮТС-ийн данс, тухайлбал, үйлдвэрлэлийн дансыг эдийн засгийн сектороор байгуулах мэдээллийг бий болгоно. Орлогын аргын тооцоо нь орлогын дансуудыг байгуулахад чиглэгдсэн байхад эцсийн ашиглалтын аргынх нь орлого ашиглалтын болон хөрөнгийн дансны мэдээллийг бүрдүүлнэ.

Дотоодын нийт бүтээгдэхүүн нь тодорхой нутаг дэвсгэр хил хязгаарын дотор нэг жилийн хугацаанд эдийн засаг болоод нийгмийн үйлчилгээний хүрээнд шинээр бүтээгдсэн нэмэгдэл өртгийн нийлбэр юм.

Энэхүү судалгаандаа тус аймгийн улсын болон баруун бүсийн эдийн засагт оруулж буй хувь нэмрийг сүүлийн 10 жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний үзүүлэлтүүдэд үндэслэн харуулахыг зорилоо.

Мөн зураг, хүснэгтийн нэрийг англиар оруулсан тул гадаадын хөрөнгө оруулагч, жуулчид манай аймгийн ДНБ-ний талаар сүүлийн 10 жилийн мэдээллийг хялбар авах боломжийг бүрдүүлээ.

**ДНБ-г тооцох мэдээллийн эх үүсвэр**  
**Data source for of the estimation of GDP**




## 2. Увс аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүнийг улс, баруун бүсийн дундажтай харьцуулах нь

Увс аймаг нь Монгол улсын баруун хойт зүгт 69.6 мянган км.кв нутаг дэвсгэртэй, 19 сум 93 багтай, 81.4 мянган хүн амтай, 2016 оны байдлаар 2784.1 мянган толгой мал тоолуулж, малын тоогоор улсад 13 дугаар байрт, баруун бүсдээ 4 дүгээр байрт орж байна.

2016 онд Аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлт оны үнээр 322.1 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 7.9 тэрбум төгрөгөөр буюу 2.4 хувиар, баруун бүсийн ДНБ 1455.1 тэрбум төгрөгт хүрч, 55.9 тэрбум төгрөгөөр буюу 3.7 хувиар тус тус буурчээ. Аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүн оны үнээр тооцсоноор 2009 оноос 2015 он хүртэл тогтмол өсч, 2016 онд өмнөх оноос 2.4 хувиар буурахад хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн салбарын бууралт голлон нөлөөлжээ.

**ДНБ, оны үнээр, сая төгрөгөөр**  
**GDP, at current price, mln.tog**

Зураг 1




Аймгуудын дунд Улаанбаатар хотын дүнг хассан үзүүлэлтээр, Орхон 1204146.7 сая төгрөгийг бүтээж 1 дүгээрт, Говьсүмбэр аймаг 81466.8 сая төгрөгийг бүтээж хамгийн бага ДНБ-тэй аймаг болж байгаа бол, Увс аймаг 21 аймгаас 12-р байрт жагсаж байна.

Увс аймаг оны үнээр тооцсоноор баруун бүсдээ хамгийн өндөр ДНБ-нийг бүтээжээ.

Зурагт үзүүлснээр аймгуудыг дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээгээр 6 бүлэгт хувааж үзвэл хамгийн өндөр буюу Улаанбаатар хот, Орхон аймгууд 12044146.7-15620117.5, Дорнод аймаг 646797.2, Хөвсгөл, Төв, Сэлэнгэ аймгууд 402322.0-646797.2, Увс, Хэнтий, Сүхбаатар, Баянхонгор, Дархан-Уул, Архангай, Өвөрхангай аймгууд 307007.7 – 402322.0, Ховд, Булган, Завхан, Өмнөговь, Дорноговь, Говь-алтай аймгууд 81366.8 - 307007.7, Говьсүмбэр аймаг 81466.8 сая төгрөгийн бүтээгдэхүүн тус тус үйлдвэрлэлээ.

**ДНБ бүс, аймаг нийслэлээр**  
**GDP by region, aimag and the capital**

Зураг 2



**ДНБ, баруун бүс, аймгаар, оны үнээр, сая төгрөгөөр**  
**GDP, western region and aimags, at current prices, mln.tog**

Хүснэгт 1

		2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016*	2016/2015
<b>Улсын дүн</b>	<b>Total</b>	<b>4,956,647.2</b>	<b>6,555,569.4</b>	<b>6,590,637.1</b>	<b>9,756,588.4</b>	<b>13,173,763.4</b>	<b>16,688,419.6</b>	<b>19,174,242.6</b>	<b>22,227,054.3</b>	<b>23,150,385.6</b>	<b>23,886,409.5</b>	<b>103.2</b>
<b>Баруун бүс</b>	<b>Western region</b>	<b>342,456.9</b>	<b>480,585.7</b>	<b>377,119.8</b>	<b>493,728.9</b>	<b>656,391.0</b>	<b>860,411.0</b>	<b>1,136,918.5</b>	<b>1,401,952.4</b>	<b>1,511,113.2</b>	<b>1,455,118.8</b>	<b>96.3</b>
Баян-Өлгий	Bayan-Olgii	60,358.2	84,661.4	69,913.9	108,299.5	143,159.4	179,619.5	232,112.1	289,666.3	311,013.7	307,007.7	98.7
Говь-Алтай	Covi-Altai	55,716.5	75,002.9	62,783.6	65,977.1	89,180.9	125,825.4	164,803.4	219,617.4	237,123.9	233,111.2	98.3
Завхан	Zavkhan	74,364.7	111,939.8	82,102.8	100,157.5	137,158.0	192,270.2	252,637.4	303,141.3	310,601.1	292,176.9	94.1
Увс	Uvs	71,077.1	93,200.8	75,929.3	106,129.4	145,132.7	182,994.4	234,561.7	292,459.2	330,085.0	322,092.8	97.6
Ховд	Khovd	80,940.4	115,780.8	86,390.2	113,165.4	141,760.0	179,701.5	252,803.9	297,068.2	322,289.5	300,730.2	93.3

Оны үнээр тооцсоноор Монгол улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 1.3 хувийг бүтээж буй Увс аймгийн улсын дүнд эзлэх хувь дорвитой нэмэгдэхгүй байгаа бөгөөд 2010-2015 онд 1.1 – 1.4 хувь болтлоо тогтмол өсч байсан ч, энэ онд өмнөх оноос 0.1 пунктээр буурч, ДНБ өсөлт багатай аймгуудын тоонд орж байна.

**ДНБ бүтэц, оны үнээр улсын дүнд эзлэх хувь, баруун бүс аймгаар**  
**GDP at current prices, percentage to total by western region, aimags**

Хүснэгт 2

		2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016*
<b>Улсын дүн</b>	<b>Total</b>	<b>100</b>	<b>100</b>	<b>100</b>	<b>100</b>	<b>100</b>	<b>100</b>	<b>100</b>	<b>100</b>	<b>100</b>	<b>100</b>
<b>Баруун бүсийн ДНБ-</b>	<b>Western region</b>	<b>20.8</b>	<b>19.4</b>	<b>20.1</b>	<b>21.5</b>	<b>22.1</b>	<b>21.3</b>	<b>20.6</b>	<b>20.9</b>	<b>21.8</b>	<b>22.1</b>
Баян-Өлгий	Bayan-Olgii	1.2	1.3	1.1	1	1.1	1.1	1.2	1.3	1.3	1.3
Говь-Алтай	Covi-Altai	1.1	1.1	1.0	0.6	0.7	0.8	0.9	1.0	1.0	1.0
Завхан	Zavkhan	1.5	1.7	1.2	0.9	1	1.2	1.3	1.4	1.3	1.2
Увс	Uvs	1.4	1.4	1.2	1.0	1.1	1.1	1.2	1.3	1.4	1.3
Ховд	Khovd	1.6	1.8	1.3	1.1	1.1	1.1	1.3	1.3	1.4	1.3

### 3. Аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүний салбарын бүтэц, харьцуулалт


Дотоодын нийт бүтээгдэхүүнийг салбараар авч үзвэл 2016 оны урьдчилсан гүйцэтгэлээр хөдөө аж ахуй ан агнуур, ойн аж ахуйн салбар оны үнээр 39.2 хувь 126260.4 сая төг, боловсруулах үйлдвэрлэлийн салбар 20.9 хувь 67317.4 сая төг, үйлчилгээний салбар 39.9 хувь буюу 128515.0 сая төгрөгийн нэмэгдэл өртөг бий болгож, өнгөрсөн оноос ДНБ-д хөдөө аж ахуйн салбарын эзлэх хувь 2.1 хувь, аж үйлдвэр барилгын салбарын эзлэх хувь 0.1 пунктээр буурч, үйлчилгээний салбарын эзлэх хувь 2.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Зураг 3-аас харахад сүүлийн жилүүдэд хөдөө аж ахуйн салбарын эзлэх хувь буурч, аж үйлдвэр, үйлчилгээний салбарын нийт үйлдвэрлэлтэнд эзлэх хувь тогтмол нэмэгдэж байгаа нь харагдаж байна. 2007 онд ХАА нь салбар аймгийн нийт үйлдвэрлэлтийн 72.0 хувийг эзэлж байсан бол 2016 онд 39.2 хувийг эзэлж, 32.8 пунктээр буурчээ.

Мөн аж үйлдвэр, барилгын салбарын нийт үйлдвэрлэлтэнд эзлэх хувь 2007 оноос 3.7 дахин нэмэгдсэн байна. Аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүний ихэнхи хувийг хөдөө аж ахуйн салбар дангаараа бүтээдэг байсан бол энэ онд үйлчилгээний салбар хөдөө аж ахуйн салбараас илүү хувийг бүтээсэн байна.

ДНБ, салбараар, хувиар  
GDP by divisions, percent

Зураг 3





**4. Аймгийн нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүнийг улс, бүсийн дундажтай харьцуулах нь**


Аймгийн нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүн энэ онд 3982.0 мянган төгрөгт хүрч өмнөх оноос 246.2 мян төгрөгөөр буюу 5.8 хувиар буурсан байна. Улсын дунджаар нэг хүнд ноогдох ДНБ 7891.4 мянган төгрөгт хүрч, Увс аймаг улсын дунджаас 3909.4 мян төгрөг буюу 49.5 хувиар бага, баруун бүсийн дундаж 3792.6 болж, Увс аймаг бүсийн дунджаас 5.0 хувиар өндөр байна. Увс аймаг дотоодын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлтээр баруун бүсдээ нэгдүгээрт орж байгаа ч, нэг хүнд ноогдох ДНБ-р бүсдээ Завхан, Говь-алтай аймгуудын дараа орж байна.

**Нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүн оны үнээр, бүс аймгаар, мян.төг  
GDP per capita, by western region, aimags, thous.tog**

		2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016*	2016/2015
		Хүснэгт 3										
Улсын дүн	<b>Total</b>	<b>1,915.6</b>	<b>2,498.4</b>	<b>2,468.2</b>	<b>3,586.1</b>	<b>4,752.8</b>	<b>5,948.6</b>	<b>6,750.8</b>	<b>7,652.9</b>	<b>7,810.3</b>	<b>7,891.4</b>	<b>101.0</b>
	<b>Western</b>											
Бүсийн дүн	<b>region</b>	<b>858.0</b>	<b>1,234.3</b>	<b>994.5</b>	<b>1,300.8</b>	<b>1,758.3</b>	<b>2,347.6</b>	<b>3,100.7</b>	<b>3,785.6</b>	<b>4,013.9</b>	<b>3,792.6</b>	<b>94.5</b>
Баян-Өлгий	Bayan-Olgii	636.6	899.1	747.9	1,188.7	1,603.4	2,017.5	2,585.2	3,147.8	3,257.5	3,114.7	<b>95.6</b>
Говь-Алтай	Covi-Altai	914.9	1,325.2	1,133.2	1,182.4	1,597.3	2,287.8	2,977	3,890.3	4,207.5	4,136.4	<b>98.3</b>
Завхан	Zavkhan	938.2	1,433.8	1,083.7	1,364.7	1,922.1	2,736.6	3,623.1	4,348.6	4,460.3	4,159.3	<b>93.3</b>
Увс	Uvs	907.3	1,189.9	982.3	1,395.1	1,945.7	2,460.9	3,131.8	3,867.1	4,228.2	3,982	<b>94.2</b>
Ховд	Khovd	893.2	1,323.7	1,025.2	1,373.1	1,723.1	2,235.3	3,186.6	3,674.4	3,915.9	3,570.5	<b>91.2</b>

**Увс аймгийн нэг хүнд ноогдох ДНБ-ны улс бүсийн дунджийн зөрүү, сая төгрөгөөр**  
**The average by total and western region difference between the GDP per capita of Uvs aimag, mln.tog**

Зураг 4



Аймгийн нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүнийг улс, баруун бүсийн дундажтай харьцуулсан графикаас харахад аймгийн нэг хүнд ноогдох ДНБ 2007- 2014 он хүртэл улсын дунджаас зөрүү нь тогтмол нэмэгдэж байсан бол 2015 онд зөрүү нь буурч, 2016 онд улсын дунджаас 3909.4 мянган төгрөгөөр доогуур байна.


Харин нэг хүнд ноогдох ДНБ-г бүсийн дундажтай харьцуулахад 2008-2009 онд 12.2-44.4 мянган төгрөгөөр доогуур, 2010-2016 онуудад бүсийн дунджаас 31.1 – 214.3 мянган төгрөгөөр өндөр байна.

**5. Дотоодын нийт бүтээгдэхүүнд хувийн хэвшлийн салбарын эзлэх хувь, харьцуулалт**

2016 оны урьдчилсан гүйцэтгэлээр Улаанбаатарын бүс нийт бүтээгдэхүүний 65.4 хувь, Хангайн бүс 13.1 хувь, Төвийн бүс 9.9 хувь, Баруун бүс 6.1 хувь, Зүүн бүс 5.5 хувийг тус тус эзэлж, өмнөх оноос Улаанбаатарын бүсийн эзлэх 0.8 хувиар өсч, Баруун бүс 0.4, Төвийн бүс 0.2, Хангайн бүс 0.1 хувиар буурч, Зүүн бүсийн улсын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь өмнөх оны мөн үеийн түвшинд байна.

**ДНБ бүтэц, бүсээр, нийт бүтээгдэхүүнд эзлэх хувиар  
GDP, by region, percentage**

Зураг 5



**ДНБ-д хувийн хэвшлийн нэмэгдэл өртгийн эзлэх хувь, аймгаар  
Private sector value added share to GDP, by aimags**

Хүснэгт 4

		2010	2011	2012	2013	2014	2015
<b>Улсын дүн</b>	<b>Total</b>	<b>76.6</b>	<b>77.8</b>	<b>78.7</b>	<b>80.1</b>	<b>79.9</b>	<b>80.0</b>
Баян-Өлгий	Bayan-Olgii	82.4	82.6	78.5	80.1	77.5	77.3
Говь-Алтай	Covi-Altai	84.7	80.7	78.9	80.6	77.8	78.1
Завхан	Zavkhan	85.2	86.1	82.9	84.1	81.9	79.4
Увс	Uvs	84.0	84.5	82.6	82.7	81.2	81.1
Ховд	Khovd	80.4	82.3	79.3	79.3	76.7	76.2

Аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүнд хувийн хэвшлийн нэмэгдэл өртгийн эзлэх хувь 2015 оны байдлаар 81.1 хувь байгаа нь улсын дунджаас 1.1 пунктээр, баруун бүсийн аймгуудаас 1.7 - 4.9 пунктээр өндөр байна. Энэ үзүүлэлт нь 2010 оноос хойш буурч

УВС АЙМГИЙН ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТАНИЛЦУУЛГА

байгаа боловч улс болон баруун бүсийн аймгуудын дүнгээс өндөр байгаа нь манай аймгийн хувийн хэвшлийн салбаруудын эдийн засагт оруулж буй хувь нэмэр өндөр байгааг харуулж байна.

Увс аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүн, салбараар, оны үнээр, 2016\* он

Gross domestic product by Uvs aimag, division, at current prices

Хүснэгт 5

Салбар	Divisions	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016*
<b>ДНБ, сая төгрөг</b>	<b>GDP, million tugrugs</b>	<b>71077.1</b>	<b>93200.8</b>	<b>75929.3</b>	<b>106129.449</b>	<b>145132.745</b>	<b>182994.399</b>	<b>234561.704</b>	<b>292459.2</b>	<b>330085</b>	<b>322092.8</b>
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	Agriculture, forestry and fishing	52969.5	59076	43203.8	47 458.6	61 780.6	83 874.8	116 815.8	129 559.4	136124.7	126260.4
Уул уурхай, олборлолт	Mining and quarrying	295.8	509.4	474.8	466.2	1 951.8	1 340.7	2 186.7	16 632.0	30853.3	67317.4
Боловсруулах үйлдвэрлэл	Manufacturing	1389.2	1409.8	2117.5	15 751.0	21 762.4	19 976.5	24 282.2	27 801.3	35773.9	
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	Electricity, gas, steam,air, conditioning			1667.9	- 1 000.0	- 1 421.4	- 2 736.2	- 679.7	3 745.5	-1328.2	
Усан хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	Water supply, sewerage, remediation activities	1484.1	1448.1	185.2	423.5	550.4	515.0	587.9	484.1	829	
Барилга	Construction	986.2	-894.3	1097.4	1 501.4	3 503.8	3 953.7	4 376.5	8 244.0	6086.5	
Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ	Wholesale and retail trade, repair of motor vehicle and motorcycles	1915.7	4056.4	3382.8	10 412.1	16 785.5	19 225.9	20 058.1	23 056.8	25540.2	128515.0
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	Transportation and storage	2485.3	4617.1	4739	3 599.7	4 263.9	5 233.3	5 887.6	6 825.5	6596.7	
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	Accommodattion and food service activities	45.3	59.5	76.8	1 062.5	1 805.4	2 253.2	2 598.3	2 466.0	2879.3	

Салбар	Divisions	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016*
Мэдээлэл, холбоо	Information and communication	-	-	13.8	137.6	203.8	252.6	244.2	349.7	320	128515.0
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	Financial and insurance activities	1458.1	1995.9	1484.7	2 707.1	4 356.9	6 126.7	8 327.0	10 633.3	12928	
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	Real estate activities	1085.4	5537.2	668.6	4 506.8	5 119.1	5 719.6	6 163.1	7 800.1	9395.4	
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	Professional, scientific and technical activities			735.1	569.8	1 094.5	1 751.6	2 117.4	2 508.8	2611.2	
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	Administrative and support service activities			9.3	114.7	35.5	49.4	64.3	117.1	159.4	
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	Public administration and defense, compulsory social security	1786.3	4493.5	3675.5	4 348.5	5 294.3	7 774.2	10 902.9	20 193.0	22735.3	
Боловсрол	Education	4374.9	8002.5	7935.4	9 124.7	11 764.1	17 206.7	19 733.5	23 912.9	26612.1	
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	Human health and social work activities	1891.9	3561.9	3404.4	3 568.5	4 463.0	6 713.2	7 969.1	10 039.8	10978.6	
Урлаг, үзвэр, тоглоом наадам	Arts, entertainment and recreation			792.5	1 116.9	1 256.7	1 929.2	2 299.3	2 949.1	3162.7	
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	Other service activities	511	919.9	264.8	259.8	562.3	1 834.4	627.5	780.6	759.5	
бүтээгдэхүүний цэвэр татвар	Net taxes on products	-1601.6	-1592.1						- 5 639.8	-2932.6	

\*2016 оны үйлчилгээний салбарын нийт дүн 128515.0 болно. Хуудас дамжсан учир 2 бичигдсэн болно.

### Энэхүү танилцуулгад ашиглагдсан тоо мэдээллийн тайлбар:

\* 2016 оны урьдчилсан гүйцэтгэл

2007-2009 оны мэдээлэл нөөц ашиглалтын 2005 оны хүснэгтэд суурилсан. 2010 оноос хойших мэдээлэл нөөц ашиглалтын хүснэгтийн 2010-2015 оны үр дүнд суурилсан.

2016 оны салбаруудын гүйцэтгэл эцэслэж гараагүй байгаа ба ХАА, аж үйлдвэр барилга , үйлчилгээний гэсэн 3 үндсэн салбараар харуулав.

#### **6. Дүгнэлт, зөвлөмж**

- 2016 онд Аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлт оны үнээр 322.1 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 7.9 тэрбум төгрөгөөр буюу 2.4 хувиар, баруун бүсийн ДНБ 1455.1 тэрбум төгрөгт хүрч, 55.9 тэрбум төгрөгөөр буюу 3.7 хувиар тус тус буурчээ.  
2016 онд Увс аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүний 39.2 хувийг хөдөө аж ахуй, 20.9 хувийг аж үйлдвэр барилга, 39.9 хувийг үйлчилгээний салбарын нэмэгдэл өртөг бүрдүүлжээ. Увс аймаг дотоодын нийт бүтээгдэхүүнээрээ улсад 12-р байрт, баруун бүсдээ 1-р байрт орж байна.
- Манай аймгийн 2015 оны нэмэгдэл өртгийн 81.1 хувийг хувийн хэвшлийн салбар бүрдүүлж байна. Энэ үзүүлэлт нь улсын болон бүсийн дунджаас өндөр үзүүлэлт бөгөөд манай аймгийн эдийн засагт хувийн хэвшлийн оруулах хувь нэмэр их байгааг харуулж байна.
- Сүүлийн жилүүдэд Хөдөө аж ахуйн салбарын ДНБ-д эзлэх хувь тогтмол буурч байгаа нь байгаль цаг уурын өөрчлөлт, малын тоо ихээхэн өссөн нь бэлчээрийн даац, хүрэлцээ хангамжийг муутгаж байгаагаас гадна хөдөө аж ахуйн салбарын өсөлтөнд нөлөөлөх эрсдэлийг багасгах арга хэмжээ авах, байгалиас бүрэн хамааралтай байдлыг бууруулах, малын ашиг шимийн үзүүлэлтийг сайжруулж, чанаржуулах шаардлагатай байна. Мөн сүү цагаан идээ, мал аж ахуйн түүхий эдийг боловсруулах жижиг дунд үйлдвэрлэл хөгжүүлэхэд анхаарах нь зүйтэй.
- 2015 оныг хүртэл ХАА-н салбар нь бусад 2 үндсэн салбараас илүү нэмэгдэл өртгийг бүтээж байсан бол 2016 онд үйлчилгээний салбар 39.9 хувь буюу өндөр хувийг бүрдүүлжээ. Энэхүү өсөлтийг цаашид бууруулахгүй барих, нэмэгдүүлэхэд анхаарах шаардлагатай.
- Аймгийн нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүн энэ онд 3982.0 мянган төгрөгт хүрч өмнөх оноос 246.2 мян төгрөгөөр буюу 5.8 хувиар буурсан байна. Улсын дунджаар нэг хүнд 7891.4 мянган төгрөгт хүрч, Увс аймаг улсын дунджаас 3909.4 мян төгрөг буюу 49.5 хувиар бага, баруун бүсийн дундаж 3792.6 болж, Увс аймаг бүсийн дунджаас 5.0 хувиар өндөр байна. Увс аймаг дотоодын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлтээр баруун бүсдээ нэгдүгээрт орж байгаа ч, нэг хүнд ноогдох ДНБ-р бүсдээ Завхан, Говь-алтай аймгуудын дараа орж байна.